

## **БАТЛАВ.**

### **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**

### **О.ЦОГТГЭРЭЛ**

## **ЧӨЛӨӨТ ЗАХ ЗЭЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЖ, ХУВИЙН ӨМЧ, ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАМГААЛАХ ТУХАЙ “ИРГЭН НЬ БАЯН МОНГОЛ” УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага**

#### **1.1 Хууль зүйн үндэслэл**

1992 онд батлагдсан Шинэ Үндсэн Хуулийн тавдугаар зүйл нь таван заалттай бөгөөд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, хоёрдугаар хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална” гэх зэргээр улсын эдийн засгийн харилцааны үндсийг тодорхой зааж хувийн өмчийг эрхэмлэсэн, олон хэвшил бүхий эдийн засагтай улс байх нийгмийн гэрээг батлан, нийтээрээ дагаж эхэлсэн. Ингэснээр нийтийн болон хувийн өмч эрх тэгш байх болон төрийн зохицуулах болон өмчлөлийн бодлого салангид байх олон улсын нийтлэг зарчим руу шилжсэн.

Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1-р хавсралтын “Эдийн засгийн эрх чөлөө” гэсэн гуравдугаар бүлгийн 3.1.2.1-д “Зах зээл дэх төрийн оролцоог бууруулж, зохицуулалтыг хялбарчлан, салбаруудын болон хувийн хэвшлийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ” гэж зааж өгсөн. Энэ нь төр биет болон биет үйлдвэрлэлийн аль ч шатанд оролцох оролцоогоо бууруулан зохицуулалтын чиг үүргээ гүйцэтгэн, салбарын чөлөөт өрсөлдөөн бий болох нөхцлийг бодлогоор дэмжихээ ил тодоор илэрхийлэн зарласан явдал гэж ойлгож байна.

#### **1.2 Практик шаардлага**

Гэвч Засгийн газраас баримтлаж буй бодлого, УИХ-аас гарч буй тогтоол, шийдвэрүүдийн нөлөөгөөр эдийн засаг дах төрийн өмчийн оролцоо өссөөр ирэх оны батлагдсан төсөвт ДНБ-ийн 38% хүрч өсчээ. Улсын төсөв ингэж өсөхийн хажуугаар салбар, чиглэл бүрт төрийн өмчит компаниудын тоо тогтмол нэмэгдсээр 400-д дөхөж байгаа бөгөөд зөвхөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын харьяанд буй 105 аж ахуйн нэгжийн нийт хөрөнгийн хэмжээ нь 105 их наяд хүрч ДНБ-ээс бараг 3 дахин их болжээ. Гэвч эдгээр компаниудаас 2,3-аас бусад нь алдагдалтай ажиллаж буй нь бидний анхаарах асуудлын нэг болсоор удлаа. Ийнхүү эдийн засгийг зохицуулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд харьяандаа аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг олноор үүсгэн байгуулах нь хувийн хэвшлийн өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. Хувийн хэвшлийн гүйцэтгэх бүрэн боломжтой ажил, үйлчилгээг явуулахаар төрийн зүгээс аж ахуйн үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийг үүсгэн байгуулж буй нь өөртөө илт давуу байдлыг бий болгон дангаар гүйцэтгэх, өрсөлдөөний тэгш байдлыг үүсгэх зүй бус үр дагаваруудтай.

Мөн шүүхийн шийдвэргүйгээр иргэн болон гадаадын иргэн, хуулийн этгээдийн өмч хөрөнгөд халдах, шүүхийн шийдвэргүйгээр дайчлах зэргээр улам бүр өмчид халтай улс болж буй олон жишээ байна. Эдгээр үндэслэл, шаардлагын улмаас хувийн өмчийг хамгаалах, бизнесийн эрх чөлөөг баталгаажуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж байна.

**Хоёр. Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Энэхүү төсөл нь тогтоолын хэлбэрээр гарах бөгөөд дараах зүйлсийг тунхаг байдлаар зааж өгнө.

1. Эдийн засгийг чөлөөлөх
2. Чөлөөт зах зээлийг хөгжүүлэх
3. Хувийн өмчийг хамгаалах
4. Эдийн засгийн эрх чөлөө, хүртээмжийг дэмжих

**Гурав. Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Тогтоолын төсөл батлагдсанаар хувийн өмчид дураар шууд халдах явдал багасч, төрийн аж ахуйн үйл ажиллагаа хязгаарлагдаж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаагаа явуулах, ажил бизнестээ хандах итгэл нэмэгдэх болно.

**Дөрөв. Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах талаар**

Энэхүү тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилготой яв цав нийцэж буй билээ.

**ХУУЛЬ САНААЧЛАГЧ**

--oOo--